



“ГРИН АССЕСМЕНТ” ХХК

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРЭГ, БОГДХАН
УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН ХЯЗГААРЛАЛТЫН БҮС,
ЗАЙСАНГИЙН АМАНД БАЙГУУЛАХ ”МОНГОЛЫН
КЕМПИНГИЙН ХОЛБОО” НҮТББ-ЫН “ОТОГЛОХ ОРОН
БАЙР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Улаанбаатар хот

2026 он

АГУУЛГА

ОРШИЛ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 1.1.1. Төслийн нэр
- 1.1.2. Төсөл хэрэгжүүлэгч
- 1.1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг
- 1.1.4. Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт
- 1.1.5. Төслийн байршил

1.2. ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХҮЧИН ЧАДАЛ

- 1.2.1. Ерөнхий төлөвлөгөө
- 1.2.2. Архитектур орон зайн төлөвлөлт
- 1.2.3. Төслийн хүчин чадал
- 1.2.3. Гудамж замын төлөвлөлт
- 1.2.4. Явган зам, дугуйн замын төлөвлөлт

1.3. ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ШИЙДЭЛ

- 1.3.1. Дулаан хангамж
- 1.3.2. Цахилгаан хангамж
- 1.3.3. Холбоо мэдээлэл
- 1.3.4. Хөдөлгөөний схем
- 1.3.5. Усан хангамж, эх үүсвэр, хэрэглээ:
- 1.3.6. Ногоон байгууламжийн төлөвлөлт, тохижилт

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Агаарын чанар
- 2.2. Хөрсөн бүрхэвч
- 2.3. Ургамлан нөмрөг
- 2.4. Амьтны аймаг
- 2.5. Гадаргын болон газрын доорх ус
- 2.6. Тусгай хамгаалалттай газар нутаг

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1. Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл
- 3.2. Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл
- 3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл
- 3.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл
- 3.5. Төслийн үйл ажиллагаанаас амьтны амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл
- 3.6. Усан орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл
- 3.7. Тусгай хамгаалалттай газар нутаг үзүүлэх нөлөөлөл
- 3.8. Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл
- 3.9. Хүний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны нөлөөллийн үнэлгээ

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

- 4.1. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг
- 4.2. Агаарын чанар
- 4.3. Гадаргын болон газрын доорх ус
- 4.4. Ургамлан нөмрөг
- 4.5. Тусгай хамгаалалттай газар нутаг
- 4.6. Удирдлага зохион байгуулалт
- 4.9. Хатуу хог хаягдлын түр цэг байгуулах болон зориулалтын хогийн савыг ашиглах
- 4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

ОРШИЛ

Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд байгуулах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс 4 км, Зайсан толгой өгсөх замын баруун хормойд байрлана.

Отоглох орон байр байгуулах төсөл нь Улаанбаатар хотын төв цэгээс 4 км зайтай, Богдхан уулын Зайсангийн аманд байрладаг. Төсөл нь үйлчилгээ бүхий 12 давхар зочид буудал байх ба нийт 0.207 га талбайд хэрэгжинэ. Нийт барилгажих талбай 785.4 м², авто зам 850.1 м², тоглоомын талбай 182.0 м², явган зам 134.22 м², ногоон байгууламж 131.5 м² байхаар төлөвлөсөн. Отоглох орон байр байгуулах төслийн барилга байгууламж нь В1, В2 зоорьтой, 1 давхарт үйлчилгээтэй, 2-12 давхарт зочид буудал байгуулахаар төлөвлөсөн. Төсөл ашиглалтад орсноор 20 ажлын байр шинээр бий болно.

Тус байгууллага нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газраас 2008 оны 8-р сарын 08-ны өдрийн №749 тоот "Улсын тусгай хамгаалалттай газарт газар ашиглах гэрчилгээг анх Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд нийт 2067 м² талбайг "Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар орон байр барих, ашиглах" зориулалтаар авсан бөгөөд сунгалтыг Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2023 оны 12-р сарын 01-ны өдрийн 01/1438 тоот саналыг үндэслэн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 6-р сарын 21-ны өдрийн А/489 тоот тушаалаар газар ашиглах эрхийг 2028 оны 6-р сарын 06-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаатай сунгуулсан байна.

Тус байгууллага нь 2024 оны 10-р сарын 09-ны өдөр "Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд газар ашиглах гэрээ"-г /№ 342 тоот/ БОУАӨЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай гурвалсан гэрээг 2028 оны 6-р сарын 06-ны өдөр хүртэлх хугацаагаар хийсэн байна.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1.1. Төслийн нэр

Отоглох орон байр байгуулах төсөл

1.1.2. Төсөл хэрэгжүүлэгч

"Монголын Кемпингийн Холбоо" НҮТББ, Улсын бүртгэлийн дугаар: 9071017019, Регистрийн дугаар: 8042306 /Аж ахуйн нэгж байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав/.

1.1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг


Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 11-р хороо, Зайсан, 156, 2 давхарт 2.7 тоот, Утас: +976 88181888, 99118707

1.1.4. Төслийн хүчин чадал, товч тодорхойлолт

Отоглох орон байр байгуулах төсөл нь Улаанбаатар хотын төв цэгээс 4 км зайтай, Богдхан уулын Зайсангийн аманд байрладаг. Төсөл нь үйлчилгээ бүхий 12 давхар зочид буудал байх ба нийт 0.207 га талбайд хэрэгжинэ. Нийт барилгажих талбай 785.4 м², авто зам 850.1 м², тоглоомын талбай 182.0 м², явган зам 134.22 м², ногоон байгууламж 131.5 м² байхаар төлөвлөсөн. Отоглох орон байр байгуулах төслийн барилга байгууламж нь В1, В2 зоорьтой, 1 давхарт үйлчилгээтэй, 2-12 давхарт зочид буудал байгуулахаар төлөвлөсөн. Төсөл ашиглалтад орсноор 20 ажлын байр шинээр бий болно.

1.1.5. Төслийн байршил

Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд байгуулах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс 4 км, Зайсан толгой өгсөх замын баруун хормойд байрлана.




Зураг 1. Төслийн байршилын тойм зураг

Тус компани нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газраас 2008 оны 8-р сарын 08-ны өдрийн №749 тоот "Улсын тусгай хамгаалалттай газарт газар ашиглах гэрчилгээг анх Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд нийт 2067 м² талбайг "Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар орон байр барих, ашиглах" зориулалтаар авсан бөгөөд сунгалтыг Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2023 оны 12-р сарын 01-ны өдрийн 01/1438 тоот саналыг үндэслэн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 6-р сарын 21-ны өдрийн А/489 тоот тушаалаар газар ашиглах эрхийг 2028 оны 6-р сарын 06-ны өдрийг хүртэл 5 жилийн хугацаатай сунгуулсан байна /Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах гэрчилгээний хуулбарыг хавсаргав/.

Хүснэгт 1. Талбайн булангийн цэгүүдийн солбицол

Газрын гэрчилгээний дугаар	Талбайн хэмжээ /м ² /	Булангийн цэгүүдийн дугаар	Солбицол		Цэгүүд
			Уртраг	Өргөрөг	
0243484	2067	1	47° 53' 4.586"	106° 54' 48.490"	1-2
		2	47° 53' 3.550"	106° 54' 48.220"	2-3
		3	47° 53' 3.571"	106° 54' 47.961"	3-4
		4	47° 53' 3.670"	106° 54' 46.750"	4-5
		5	47° 53' 4.510"	106° 54' 47.070"	5-6
		6	47° 53' 6.370"	106° 54' 47.220"	6-7
		7	47° 53' 3.370"	106° 54' 47.830"	7-8
		8	47° 53' 5.370"	106° 54' 47.916"	8-9
		9	47° 53' 5.240"	106° 54' 48.660"	9-1

Тус компани нь 2024 оны 10-р сарын 09-ны өдөр "Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд газар ашиглах гэрээ"-г /№ 342 тоот/ БОУАӨЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай гурвалсан гэрээг 2028 оны 6-р сарын 06-ны өдөр хүртэлх хугацаагаар хийсэн байна /Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээний хуулбарыг хавсаргав/.



Зураг 2. Байршлын зураг

1.2. ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХҮЧИН ЧАДАЛ

1.2.1. Ерөнхий төлөвлөгөө

Зайсагийн аманд байрлах Отоглох орон байр байгуулах төсөл нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт хамаарна. Нийслэл хотын төвөөс 4 км зайд бүрэн үйлчилгээ бүхий зочид буудал байгуулах бүтээн байгуулалт юм.

Тус Отоглох орон байр байгуулах төсөл нь үйлчилгээ бүхий 12 давхар зочид буудал байх ба нийт 0.207 га талбайд хэрэгжинэ. Нийт барилгажих талбай 785.4 м², авто зам 850.1 м², тоглоомын талбай 182.0 м², явган зам 134.22 м², ногоон байгууламж 131.5 м² байхаар төлөвлөсөн. Отоглох орон байр байгуулах төслийн барилга байгууламж нь В1, В2 зоорьтой, 1 давхарт үйлчилгээтэй, 2-12 давхарт зочид буудал байгуулахаар төлөвлөсөн.

1.2.2. Архитектур орон зайн төлөвлөлт

Тус бүтээн байгуулалт хийгдэх нийт 2067 м² талбай байх бөгөөд дараах барилга байгууламж баригдана.

Хүснэгт 2. Барилгажих талбайн хэмжээ

№	Барилгажих талбайн нэр	Эзлэх талбай /м ² /	Эзлэх хувь /%/
1.	Барилга байгууламж	785.4	38.0
2.	Авто зам	850.1	41.0
3.	Тоглоомын талбай	182.0	9.0
4.	Явган зам	134.22	6.0
5.	Ногоон байгууламж	131.5	6.0
Нийт		2067.0	100.0

Хүснэгт 3. Үйлчилгээний төвийн хүчин чадал

Өрөөний нэрс		Талбай /м ² /	Өрөөний тоо
Оффис, худалдаа үйлчилгээ		167.07	8
1.	Оффис /танхим/	39.88	1
2.	Ариун цэврийн өрөө	2.11	1
3.	Кофе Шоф	46.53	1
4.	Ариун цэврийн өрөө	2.54	1
5.	Түрээсийн талбай	33.5	1
6.	Ариун цэврийн өрөө	2.11	1
7.	Ариун цэврийн өрөө	3.24	1
8.	Хувцас солих өрөө	3.68	1
9.	Хувцасны өрөө	3.58	1
10.	Түрээсийн талбай	38.9	1
Фитнес заал		208.28	5
11.	Фитнес лобби	30.39	1
12.	Фитнес заал	131.78	1
13.	Ариун цэврийн өрөө	13.49	1
14.	Дүш /Эмэгтэй/	16.0	1
15.	Дүш /эрэгтэй/	16.62	1
Нийтийн талбай		348.78	9
16.	Хүлээн авах хэсэг	62.77	1
17.	Үүдний гонх	12.32	1
18.	Коридор	11.07	1
19.	Шатны хонгил	15.81	1
20.	Коридор	28.35	1
21.	Гонх	3.60	1
22.	Цахилгаан шат хонгил – 1	4.18	1
23.	Цахилгаан шат хонгил – 2	4.18	1

24.	Гадна террас	206.49	1
Бүгд дүн		733.13	24

Хүснэгт 4. Зоорийн давхрын хүчин чадал

Өрөөний нэрс		Талбай /м²/	Өрөөний тоо
B1-р давхар		752.93	8
1.	Коридор	11.07	1
2.	Шатны хонгил	15.81	1
3.	Цахилгаан шат хонгил – 1	4.18	1
4.	Цахилгаан шат хонгил – 2	4.18	1
5.	Техникийн өрөө	16.48	1
6.	Техникийн өрөө	11.13	1
7.	Авто зогсоол	480.73	1
8.	Авто зогсоол	209.34	1
B2-р давхар		752.82	7
9.	Авто зогсоол	511.13	1
10.	Шатны хонгил	15.81	1
11.	Коридор	11.07	1
12.	Цахилгаан шат хонгил – 1	4.18	1
13.	Цахилгаан шат хонгил – 2	4.18	1
14.	Авто зогсоол	139.52	1
15.	Нөөцийн савны өрөө	66.93	1
Техникийн давхар		620.68	10
16.	Лифт засварын талбай	23.63	1
17.	Шатны хонгил	16.83	1
18.	Коридор	25.42	1
19.	Ариун цэврийн өрөө	2.82	1
20.	СӨХ-ийн өрөө	13.89	1
21.	Техникийн өрөө	27.16	1
22.	Ариун цэврийн өрөө	2.82	1
23.	Техникийн өрөө	12.63	1
24.	Террас	250.3	1
25.	Террас	245.17	1
Бүгд дүн		2126.43	25

Хүснэгт 5. Гэр бүлийн зориулалттай зочид буудлын хүчин чадал

Өрөөний нэрс		Талбай /м²/	Өрөөний тоо
2-р давхар		460.15	31
1.	Нийтийн талбай	81.39	5
2.	“А” зочид буудал	107.0	7
3.	“В” зочид буудал	82.38	6
4.	“С” зочид буудал	92.62	7
5.	“D” зочид буудал	96.77	6
3-6 дугаар давхар		621.8	47
6.	Нийтийн талбай	90.55	5
7.	“А” зочид буудал	107.85	9
8.	“В” зочид буудал	74.95	6
9.	“С” зочид буудал	79.83	6
10.	“D” зочид буудал	79.83	6
11.	“E” зочид буудал	74.12	6
12.	“F” зочид буудал	114.68	9
7-10 дугаар давхар		630.39	45
13.	Нийтийн талбай	74.99	5

14.	“А” зочид буудал	120.38	7
15.	“В” зочид буудал	154.55	13
16.	“С” зочид буудал	153.44	13
11-12 дугаар давхар		637.09	44
17.	Нийтийн талбай	61.98	4
18.	“А” зочид буудал	283.46	20
19.	“В” зочид буудал	291.66	20
Нийт		2349.43	167

1.2.3. Төслийн хүчин чадал

Отоглох орон байр байгуулах төслийн барилга байгууламж нь В1, В2 зоорьтой, 1 давхарт үйлчилгээтэй, 2-12 давхарт зочид буудал байгуулахаар төлөвлөсөн. Төслийн бүрэн хүчин чадлыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6. Төслийн хүчин чадал

Өрөөний нэрс		Талбай /м²/	Өрөөний тоо	Хүчин чадал /хүн/
1.	Оффис, худалдаа үйлчилгээ	167.07	8	150
2.	Фитнес заал	208.28	5	30
3.	Гэр бүлийн зориулалттай зочид буудал	2349.43	167	400
4.	Төслийн ажилчид	-	-	20
Нийт				250

Төслийн хүчин чадлыг 1-12 дугаар сард 20-70%-ийн дүүргэлттэй байхаар төлөвлөсөн төлөвлөсөн тооцоог дараах хүснэгтэд үзүүлэв.

Тооцооллоос үзвэл төслийн хүчин чадал нь жил дунджаар оффис, худалдаа үйлчилгээний төвд – 23775 хүн, фитнес зааланд – 4485 хүн, гэр бүлийн зориулалттай зочид буудалд – 63400 хүн, нийт нэг жилийн хугацаанд 91660 хүн/жил үйлчлүүлэхээр байна.

Хүснэгт 7. Төслийн хүчин чадлын дэлгэрэнгүй тооцоо

№	Үзүүлэлт	Хүчин чадал /м²/	Хэмжих нэгж	Жилд ажиллах сар												Нийт
				1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	
1.	Оффис, худалдаа үйлчилгээний төв	524.85	хүн/сар	1395	1260	1395	1800	2325	2700	3255	2790	2250	1860	1350	1395	23775
	1.1 Хоногийн хүчин чадал	-	хүн/хоног	150	150	150	150	150	150	150	150	150	150	150	150	
	1.2 Сард ажиллах хоног	-	хоног	31	28	31	30	31	30	31	31	30	31	30	31	
	1.3 Хүчин чадал ашиглалт	-	хувь	30%	30%	30%	40%	50%	60%	70%	60%	50%	40%	30%	30%	
2.	Фитнес заал	208.28	хүн/сар	186	168	279	360	465	540	651	558	450	372	270	186	4485
	1.1 Хоногийн хүчин чадал	-	хүн/хоног	30	30	30	30	30	30	30	30	30	30	30	30	
	1.2 Сард ажиллах хоног	-	хоног	31	28	31	30	31	30	31	31	30	31	30	31	
	1.3 Хүчин чадал ашиглалт	-	хувь	20%	20%	30%	40%	50%	60%	70%	60%	50%	40%	30%	20%	
3.	Гэр бүлийн зориулалттай зочид буудал	2349.43	хүн/сар	3720	3360	3720	4800	6200	7200	8680	7440	6000	4960	3600	3720	63400
	1.1 Хоногийн хүчин чадал	-	хүн/хоног	400	400	400	400	400	400	400	400	400	400	400	400	
	1.2 Сард ажиллах хоног	-	хоног	31	28	31	30	31	30	31	31	30	31	30	31	
	1.3 Хүчин чадал ашиглалт	-	хувь	30%	30%	30%	40%	50%	60%	70%	60%	50%	40%	30%	30%	
НИЙТ																
4.	Төслийн ажилчид	167.07	хүн/сар	20	20	20	20	20	20	20	20	20	20	20	20	240
БҮГД																91660

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР Ч.ТӨГСДЭЛГЭР




Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо
"Монголын кемпингийн холбоо" НҮТББ -ийн

БУУДАЛЛАХ, ОТОГЛОХ ОРОН БАЙР

/ЗАГВАР ЗУРАГ/


Хянасан.

Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Боловсруулсан.	Гүйцэтгэгч
Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга	Ц.Уранчимэг			Албан тушаал Нэр "Дондовжан" ХХК-ийн Захирал О.Тэлмүүн
Хот байгуулалт, Хотын стандартын газрын хот төлөвлөлтийн хэлтсийн дарга	Б.Батцолмон		Захиалагч	
Хот байгуулалт, Хотын стандартын газрын хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн	М.Эрдэнэжигд		Албан тушаал Нэр "Монголын кемпингийн холбоо" НҮТББ -ийн захирал М.Чинсанаа	Гарын үсэг 



Улаанбаатар хот 2026 он

Зураг 3. Баталгаажсан зураг



Зураг 4. Ерөнхий төлөвлөгөөний зураг



Зураг 5. Харагдах байдал /Хойд талаас/



Зураг 6. Харагдах байдал /Зүүн хойд талаас/




Зураг 7. Харагдах байдал /Баруун хойд талаас/



Зураг 8. Харагдах байдал /Баруун талаас/




Зураг 9. Харагдах байдал /Зүүн талаас/



Зураг 10. B1 давхрын байгуулалтын зураг

В2 ДУГААР ДАВХРЫН БАЙГУУЛАЛТ



В2-Р ДАВХРЫН ӨРӨӨНИЙ ТОДОРХОЙЛОЛТ		
Д/д	Нэр	Талбай
B09	Автом зогсоол	511.13 м²
B10	Шатны хөнгөл	15.81 м²
B11	Коридор	11.07 м²
B12	Цахилгаан шат хөнгөл-1	4.18 м²
B13	Цахилгаан шат хөнгөл-2	4.18 м²
B14	Автом зогсоол	139.52 м²
B15	Нөөцийн савны өрөө	66.93 м²
Нийт талбай: 7		752.82 м²

	"Монголын кемпингийн холбоо" НҮТББ Буудаллах, отоглох байр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо	Нэр	Гарын үсэг	Зогвар зураг
	"Дондовжан" ХХК-ийн захирал	О.Төмүүн		M1 : 175
	Архитектор	Н.Төртөгтох		Хуудас 09
"ДОНДОВЖАН ХХК"	"Монголын кемпингийн холбоо" НҮТББ захирал	М.Чинсанаа		2026 он

Зураг 11. В2 давхрын байгуулалтын зураг

1 ДҮГЭЭР ДАВХРЫН БАЙГУУЛАЛТ



1-Р ДАВХРЫН ӨРӨӨНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	Нэр	Талбай
Фитнесс заал		
106	Фитнесс лобби	30.39 м²
107	Фитнесс заал	131.78 м²
108	Ариун цэврийн өрөө	13.49 м²
109	Дүш/эмэгтэй/	16.00 м²
110	Дүш/эрэгтэй/	16.62 м²
Фитнесс заал: 5		208.28 м²
Оффис, Худалдаа үйлчилгээ		
113	Оффис/танхим/	39.88 м²
114	Ариун цэврийн өрөө	2.11 м²
115	Кофе Шоф	46.53 м²
116	Ариун цэврийн өрөө	2.54 м²
117	Түрээсийн талбай	33.50 м²
118	Ариун цэврийн өрөө	2.11 м²
119	Ариун цэврийн өрөө	3.24 м²
120	Хувцас солих өрөө	3.68 м²
121	Хувцасны өрөө	3.58 м²
122	Түрээсийн талбай	38.90 м²
Оффис, Худалдаа үйлчилгээ: 10		176.07 м²
Нийтийн талбай		
101	Хүлээн авах хэсэг	62.77 м²
100	Үүдний гонх	12.32 м²
102	Коридор	11.07 м²
103	Шатны хонгил	15.81 м²
104	Коридор	28.35 м²
105	Гонх	3.60 м²
111	Цахилгаан шат хонгил-1	4.18 м²
112	Цахилгаан шат хонгил-2	4.18 м²
123	Гадна террас	206.49 м²
Нийтийн талбай: 9		348.78 м²
Нийт талбай: 24		733.13 м²

Таних тэмдэг

- Нийтийн талбай
- Оффис, Худалдаа үйлчилгээ
- Фитнесс заал




"Монголын кемпингийн холбоо" НҮТББ Буудаллах, отоглох байр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо			
"Дондовжан" ХХК-ийн захирал	О.Талмүүн	Гарын үсэг	Загвар зураг
Архитектор	Н.Төртөгтох	Хуудас 11	
"ДОНДОВЖАН ХХК" "Монголын кемпингийн холбоо" НҮТББ захирал	М.Чинсанаа	2026 он	

Зураг 12. 1 дүгээр давхрын байгуулалтын зураг



Зураг 13. 2 дүгээр давхрын байгуулалтын зураг



Зураг 14. 3-6 дугаар давхрын байгуулалтын зураг

7-10-Р ДУГААР ДАВХРЫН БАЙГУУЛАЛТ



7-10-Р ДАВХРЫН ӨРӨННИЙ ТОДОРХОЙЛОЛТ		
Д/д	Нэр	Талбай
Нийтний талбай:		
HT-01	Коридор	37.08 м²
HT-02	Коридор	13.87 м²
HT-04	Шатны хонгил	15.68 м²
ЦХ-2	Цахилгаан шат хонгил-2	4.18 м²
ЦХ-1	Цахилгаан шат хонгил-1	4.18 м²
Нийтний талбай: 5		74.99 м²
"B" АЙЛ		
B01	Үүдний хэсэг	4.38 м²
B02	Коридор	9.72 м²
B03	Зочны өрөө Гал тогоо	54.10 м²
B06	Ариун цэврийн өрөө	6.24 м²
B07	Ариун цэврийн өрөө	8.60 м²
B05	Унтлагын өрөө	11.16 м²
B04	Унтлагын өрөө	12.27 м²
B09	Унтлагын өрөө / мастер/	15.21 м²
B08	Ариун цэврийн өрөө	6.67 м²
B10	Тагт	4.92 м²
B13	Тагт	10.90 м²
B11	Тагт	6.40 м²
B12	Тагт	5.97 м²
"B" АЙЛ: 13		154.55 м²
"A" АЙЛ		
A01	Үүдний хэсэг	13.32 м²
A03	Зочны өрөө Гал тогоо	55.84 м²
A04	Ариун цэврийн өрөө	7.22 м²
A06	Ариун цэврийн өрөө	7.56 м²
A05	Унтлагын өрөө / мастер/	13.83 м²
A02	Унтлагын өрөө	12.83 м²
A07	Тагт	9.77 м²
"A" АЙЛ: 7		120.38 м²
"D" АЙЛ		
D01	Үүдний хэсэг	14.02 м²
D03	Унтлагын өрөө	12.83 м²
D04	Зочны өрөө Гал тогоо	60.01 м²
D05	Унтлагын өрөө / мастер/	15.17 м²
D06	Ариун цэврийн өрөө	7.56 м²
D02	Ариун цэврийн өрөө	7.22 м²
D07	Тагт	10.22 м²
"D" АЙЛ: 7		127.04 м²
"C" АЙЛ		
C01	Үүдний хэсэг	4.38 м²
C02	Коридор	10.14 м²
C03	Зочны өрөө Гал тогоо	53.01 м²
C05	Унтлагын өрөө	12.27 м²
C04	Унтлагын өрөө	11.16 м²
C12	Тагт	5.96 м²
C11	Тагт	6.40 м²
C07	Унтлагын өрөө / мастер/	15.21 м²
C06	Ариун цэврийн өрөө	6.67 м²
C10	Тагт	4.92 м²
C13	Тагт	10.55 м²
C08	Ариун цэврийн өрөө	6.53 м²
C09	Ариун цэврийн өрөө	6.24 м²
"C" АЙЛ: 13		153.44 м²
Нийт талбай: 45		630.39 м²

Таних тэмдэг


"C" АЙЛ	"A" АЙЛ	Нийтийн талбай
"D" АЙЛ	"B" АЙЛ	



"Монголын кемпингийн холбоо" НҮТББ Буудаллах, отоглох байр Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо			
"Дондовжан" ХХК-ийн захирал		Нэр	Гарын үсэг
Архитектор		Н.Төртөгтох	Хуудас 14
"ДОНДОВЖАН ХХК" "Монголын кемпингийн холбоо" НҮТББ захирал		М.Чинсанаа	2026 он

Зураг 15. 7-10 дугаар давхрын байгуулалтын зураг

11-12 ДУГААР ДАВХРЫН БАЙГУУЛАЛТ



Зураг 16. 11-12 дугаар давхрын байгуулалтын зураг

1.2.3. Гудамж замын төлөвлөлт

Идэвхтэй хөдөлгөөн, амьд орчныг бүрдүүлэх зорилгоор тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэлээд хязгаарласан бөгөөд гол үйлчилгээ, амрагчдын байрлах сууцны бүс рүү орсон байдлаар авто замыг төлөвлөсөн байна.

Дэд бүтцийн төлөвлөлт: Отоглох орон байр байгуулах төслийн орон сууцны хэмжээнд нийт 850.1 м² талбайд авто зам, 134.22 м² талбайд явган хүний зам байгуулахаар төлөвлөсөн байна. Эдгээрээс В1-р давхар 690.07 м² талбайд, В2-р давхар 650.65 м² талбайд авто зогсоол байгуулахаар төлөвлөсөн байна.

1.2.4. Явган зам, дугуйн замын төлөвлөлт

Авто машингүй гудамж буюу явган хүн, дугуйн хөдөлгөөнийг дэмжсэн гудамжнууд нь өөр хоорондоо шууд огтлолцох бөгөөд энэ нь амрагчид зорчиход ойлгомжтой, аюулгүй мэдрэмж төрүүлж байдаг учир ашиглалт сайн байдаг.

Явган болон дугуйн замын хучилтын төрөл:

Дугуйн зам:

- ✓ Асфальт бетон хучилт, эсвэл өнгөт хавтан
- ✓ Дагуу налуу хамгийн ихдээ 4%-аас багагүй байх.
- ✓ Өргөн 1 м буюу нэг урсгалтай байхаар төлөвлөсөн байна.

Явган зам:

- ✓ Өнгөт хавтан
- ✓ Дагуу налуу хамгийн ихдээ 4%-аас багагүй байх.
- ✓ Өргөн 1 м буюу дугуйн замтай зэрэгцэж байхаар төлөвлөсөн байна.

1.3. ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ШИЙДЭЛ

Тус байгууллага нь дэд бүтцийн төлөвлөлтийг дараах байдлаар шийдвэрлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 8. Дэд бүтцийн төлөвлөлт, шийдэл

Ангилал	Тайлбар
Цахилгаан	Эрчим хүчний нэгдсэн системд холбогдоно. /110/35/10 дэд станцаас 4 ширхэг Ф240 өндөр хүчдэлийн ЦДКШ-аар 2х1600кВА ХТП/
Халаалт	Улаанбаатар хотын төвийн дулааны нэгдсэн системд холбогдоно.
Бохир ус	Улаанбаатар хотын бохир усны нэгдсэн системд холбогдоно.
Цэвэр ус	Гүний худгаар хангана. Төслийн усны хэрэглээг "Жинхэнэ-Уянга" ХХК-ийн эзэмшлийн 4.0 л/сек ундаргатай гүний худгаас хангана. Тус компани ус ашиглах гэрээтэй.

1.3.1. Дулаан хангамж

Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд байгуулах "Монголын Кемпингийн Холбоо" НҮТББ-ын "Отоглох орон байр байгуулах төсөл"-ийн байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврын дагуу дулаан хангамжийн хөгжлийн ерөнхий төлөвлөлтийг дор дурдсан бичиг баримтыг үндэслэн боловсруулсан байна. Үүнд:

- ✓ № 2025/00-1018, 2025-09-05 өдрийн архитектор төлөвлөлтийн даалгавар
- ✓ УББ 11-202-00 Хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар

- ✓ Монгол улсын эрчим хүчний хөгжлийн концепци 2018 он
- ✓ БНБД 41-02-13 Дулааны сүлжээ
- ✓ БНБД 23-01-09 Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт
- ✓ БНБД 25-01-20 Барилгын дулаан хамгаалалт

Тооцооны параметрууд:

- ✓ Сүлжээний өгөх усны температур -95°C
- ✓ Сүлжээний буцах усны температур - 65°C тооцов.

Цаг уурын нөхцөл:

- ✓ Гадна агаарын хамгийн их температур -39.4°C
- ✓ Гадна агаарын 5 хоногийн дундаж температур -34.2°C
- ✓ Хамгийн халуун үеийн 1 хоногийн температур - +25.8°C
- ✓ Халаалтын галлагаа үргэлжлэх хоног -15.IX - 12.V хүртэл 239 хоног
- ✓ Салхины дундаж хурд жилийн 2.3м/сек
- ✓ Улирлын хөлдөлтийн гүн - 2.78 - 3.97м

1.3.2. Цахилгаан хангамж

Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд байгуулах "Монголын Кемпингийн Холбоо" НҮТББ-ын "Отоглох орон байр байгуулах төсөл"-ийн цахилгаан хангамж, холбооны төлөвлөлтийн даалгаврын үндэслэн хийнэ.

- ✓ "Орон сууц болон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмж төлөвлөх ба угсрах" барилгын дүрэм БД43-101-03.
- ✓ "Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг" БНБД23-02-08, дүрэм БД43-103-08.
- ✓ "Цахилгаан техникийн ажил" БНБД3.05.06-90-ын дагуу хийж гүйцэтгэв.
- ✓ "Орон сууц олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах" барилгын дүрэм БД43-102-07-д зааснаар цахилгаан хэрэглэгчид нь цахилгаан хангамжийн хайдваржилтын 3-р зэрэгт хамаарагдана.

Тооцоолсон ачаалалд зориулан төслийн талбайд РП 10кВ бүхий 110/35/10 дэд станцаас 4 ширхэг Ф240 өндөр хүчдэлийн ЦДКШ-аар 2х1600кВА ХТПП байна.

Аж ахуйн бүс, амралтын бүс гэх мэт төрлөөр нь ангилан тус бүрийн хамаарагдах талбайд хуваарилах самбар байрлуулан хэрэглэгчдийг тэжээнэ. Мөн зам талбайн гэрэлтүүлгийн тэжээлийн кабелийн уртын хэмжээг ажлын зургийн шатанд тодорхой болгоно.

1.3.3. Холбоо мэдээлэл

Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд байгуулах "Монголын Кемпингийн Холбоо" НҮТББ-ын "Отоглох орон байр байгуулах төсөл"-ийн цахилгаан хангамж, холбооны төлөвлөлтийн даалгаврыг үндэслэн


- ✓ "Орон сууц болон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмж төлөвлөх ба угсрах" барилгын дүрэм БД43-101-03,
- ✓ "Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг" БНБД23-02-08, дүрэм БД43-103-08,
- ✓ "Цахилгаан техникийн ажил" БНБД3.05.06-90-ын дагуу хийж гүйцэтгэв.

Төслийн тохижуулалтад зориулан татах шилэн кабелийн уртыг тухайн үед нь үйлчилгээ үзүүлэх байгууллагын төхөөрөмж шилэн кабелийн трасс, байршлаас хамааруулан тооцох.

Автомашинь хөдөлгөөн нь 2 чигийн урсгалтай байх ба хөдөлгөөний эрчим их биш учир амрагчдын байрлах сууцны хэсгээс буцаж эргэх маягаар мухар зам төлөвлөсөн нь авто замын талбайн хэмжээг багасгаж зардлыг бууруулна. Амрагчдын амрах орчин болон хувийн орон зайг бий болгох үүднээс сууцны хэсэгт автоматаар буух хаалт байрлуулна.

Явган зам болон дугуйн замын хөдөлгөөн нь төслийг бүхэлд нь хамарсан тойрог хэлбэрээр төлөвлөгдсөн ба амрагчдын байрлах сууцны хэсгийг үйлчилгээний хэсэг, ногоон байгууламж, спортын байгууламж гэх мэт бүсүүдтэй холбож өгснөөр амарч буй нийт амрагчдын оролцож болох үйл ажиллагаа, хөдөлгөөнийг идэвхжүүлж өгнө.

Амрагчдын байрлах каластер бүр хоорондоо модон явган замаар холбогдсон байна.



Зураг 17. Зорчих хөдөлгөөний зураг

1.3.5. Усан хангамж, эх үүсвэр, хэрэглээ:

Отоглох орон байр байгуулах төсөлд шаардагдах $91.66 \text{ м}^3/\text{хон}$ усны хэрэглээг "Жинхэнэ Уянга" ХХК-ийн 4.0 л/сек ($345.6 \text{ м}^3/\text{хон}$) ундаргатай гүний худгаас хангахад усны ашиглах боломжит хүрэлцээтэй /Усны боломжит нөөцийн дүгнэлтийг хавсаргав/.

Харин хаягдал усыг Улаанбаатар хотын бохир ус зайлуулах нэгдсэн системд холбоно.

Төслийн усны хэрэглээг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОУАӨЯ-аар батлагдсаны дараа Нийслэлийн Байгаль орчны газраас гүний худаг гаргах зөвшөөрөл авч, гүний худаг шинээр гарган ашиглана. Гүний худгийн хүчин чадалд тулгуурлан Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт, ус ашиглуулах дүгнэлтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газраар, ус ашиглах зөвшөөрөл, гэрээг Туул голын сав газрын захиргаатай хийхээр төлөвлөсөн.

Төсөл нь 2027 оноос ашиглалтад орж үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн.

Төслийн үйлчлүүлэгч, ажилчдын ахуйн хэрэглээний усыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай" тушаалын 13-р хавсралтаар тогтоосон "Нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын ус хэрэглээний норм"-ын 1, 23, 24 дэх хэсэгт заасан ус хэрэглээний нормоор тооцов.

Ногоон байгууламжийн усны хэрэглээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай" тушаалын 14-р хавсралтаар тогтоосон "Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм"-ын 1, 2, 3 дахь хэсэгт заасан ус хэрэглээний нормоор тооцов.

Дараах хүснэгтэд 2026 онд буюу барилгын ажлын үед ашиглах техникийн болон ногоон байгууламжийн усны хэрэглээг тооцож оруулав.

Хүснэгт 9. Төслийн технологийн болон ахуйн жилийн усны хэрэглээ


№	Үзүүлэлт	Зориулалт	Хүчин чадал /хүн/жил/	Ажиллах хоног	Норм /м³/	Хоногийн усны хэрэглээ (м³/хон)	Жилийн усны хэрэглээ (м³/жил)
1.	Ахуйн хэрэглээ	Барилгын ажилчид	40 хүн	120	0.15	6.0	720.0
2.		Төслийн ажилчид	20 хүн	120	0.15	3.0	360.0
3.	Ногоон байгууламжийн усалгаа	Суулгац /Мод/	1020 ш	10	0.04	40.8	408.0
4.	Зам усалгаа		200 м²	10	0.02	4.0	40.0
Нийт дүн							1528.0

1.3.6. Ногоон байгууламжийн төлөвлөлт, тохижилт

Төлөвлөж буй амрагчдын барилгын бүс бүрийг тусгаарласан ногоон байгууламж, тохижилтыг төлөвлөж өгсөн бөгөөд нөмөртэй, тав тух мэдрүүлэх мод, бут сөөгийг нормын дагуу төлөвлөсөн. Барилгын гол зам дагуу дуу чимээ сарниулах, тоос бохирдлоос хамгаалах зорилгоор бутлаг шигүү, сөөглөг ургамлууд болон ургах чадвар сайтай өндөр моднууд тарихаар тооцсон байна.

№	Ногоон байгууламжийн ангилал	Модны төрөл /Хайлаас, ш/	Модны төрөл /Шар хуайс, ш/	Зүлэгжүүлэлт /м²/	Ногоон байгууламжийн эзлэх хувь /%/
1.	Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж	16	1000	131.5	6%
2.	Хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламж	4	0	0	0
Нийт		20	1000	131.5	6%

Хязгаарлагдмал зориулалт бүхий ногоон бүс. Задгай агаарт дасгал, спортоор хичээллэх, хүүхдүүдэд тусгайлан зориулагдсан тоглоомоор тоглох, сууцны хэсгүүдийн гадна талбайн ногоон байгууламж зэрэгт уг төрөлд хамаарна. Уг төрөлд зүлэг ширэг голдуу байх бөгөөд байгалийн хэлбэр төрхийг хадгалсан мод бутыг сонгож тарих хэрэгтэй.



Зураг 18. Ногоон байгууламжийн төлөвлөлтийн зураг

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Агаарын чанар

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хээрийн судалгааны ажлын хүрээнд төслийн талбайг төлөөлж чадахуйц 2 цэг сонгон, 2 давталттайгаар хий төлөвт агаар бохирдуулагчдын сорьц авч агаарын чанарын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлсон. Хээрийн судалгаагаар төслийн нийт талбайн хэмжээнд агаарын 16 сорьц авсан.

Шинжилгээний үр дүнгээс харахад төслийн талбай орчмын агаар дахь хий төлөвт бохирдуулагч болох SO_2 хэмжилт 0.022- 0.027 мкг/м^3 , NO_2 хэмжилт 0.027- 0.031 мкг/м^3 , CO хэмжилт 0.026- 0.028 мг/м^3 байгаа нь агаар бохирдуулагч хийн төлөвт бодисын түвшин Монгол улсын агаарын чанарын стандарт MNS4 585:2025-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарт байна.

Агаар бохирдуулагч тоосонцрын хэмжилтээр төслийн талбайг төлөөлөхүйц 2 байршлыг сонгон агаар дахь нийт тоос, PM_{10} , $\text{PM}_{2.5}$ тоосонцрын агууламжийг тодорхойлсон бөгөөд нийт тоос 0.025-0.031 мг/м^3 , PM_{10} 0.024-0.036 мг/м^3 , $\text{PM}_{2.5}$ 0.029-0.031 мг/м^3 байгаа нь агаар бохирдуулагч хийн төлөвт бодисын түвшин Монгол улсын агаарын чанарын стандарт MNS4 585:2025-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарт байна.

Судалгааны үеэр дуу шуугианы хамгийн их түвшин 25 дБ(А)-ээс хэтрээгүй бөгөөд Монгол улсын агаарын чанарын стандарт MNS4 585:2025-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаарт, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь дуу шуугианаар бохирдоогүй байна.

2.2. Хөрсөн бүрхэвч

Хөрсөн бүрхэвчийн судалгааны явцад 2-н цэгээс шимт хөрсний буюу 0-40 см гүнээс дээжлэлт хийж 12 ширхэг дээж авсан.

Хөрсний гадаргын ба үе давхаргын морфологи шинж чанарыг нэгтгэн дүгнэвэл хөрсний гадарга дээр чулууны бүрхэц маш бага, ургамал бүрхэц 60-80%, элс болон давсны хуримтлал байхгүй, хүний нөлөөтэй эвдрэл талхагдал бага, газрын гадарга нь хойноос баруун урагшаа чиглэсэн 4-8 градус налуу гадаргатай, дов сондуул дунд зэрэг байна. Чийгэрхүү, тод хар хүрэн өнгөтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, сайр чулуу 0-5%, том бөөмөрхөг бүтэцтэй, ургамлын нарийн үндэс олон, сийрэгдүү нягтшилтай, карбонатгүй, үе давхаргын шилжилт өнгөөр аажим, үндсээр тод ялгарна.

Хөрсний агро - хими, физик шинж чанарын хувьд хөрсний урвалын орчин (pH) 7.29-7.92 хооронд буюу сул хүчиллэгээс саармаг урвалын орчинтой байгаа нь ургамал ургахад нэн тохиромжтой байна. Хөрсний карбонатын агууламж 0.0% буюу карбонатгүй байгаа нь тухайн хөрсний чийг хурдан уурших, салхи болон усны элэгдэл эвдрэлд тэсвэр муутай.

Хөрсөн бүрхэвчийн ялзмагийн агууламж 2.02-2.62%-ийн хооронд буюу өндөр агууламжтай, доод үе давхаргуудад 2.021-3.456% агууламжтай байгаа нь тухайн хөрс ялзмагийн нөөц их байгааг илтгэж байна. Хөрсний ЕС-ийн утгын хэлбэлзэл 0.146-0.756 dS/m хооронд буюу маш сул давсархаг байна. Хөрсөн бүрхэвчийн хөдөлгөөнт фосфорын хангамж багаас дунд зэрэг хангамжтай, хөдөлгөөнт калийн хувьд маш сайн хангамжтай, нийт агууламж өндөр байна. Хөрсний механик (ширхгийн) бүрэлдэхүүний хувьд тоос болон элсэн фракцын эзлэх хувь өндөр буюу элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүн, амьтан, ургамлын өсөлт хөгжилтөд сөрөг нөлөө үзүүлдэг, янз бүрийн өвчин үүсгэх эх үүсвэр болдог 12 хүнд металл байдаг. Эдгээрийг дотор нь онцгой хортой болон био-идэвхт гэж ангилдаг. Төслийн талбайгаас 4 цэгийг сонгож өнгөн үе давхаргын 2 дээжид хүнд металлын шинжилгээ хийлгэхэд дараах 10 хүнд металл тодорхой хэмжээгээр илэрсэн байна. Үүнд: хар тугалга (Pb), хром (Cr), цайр (Zn), кобальт (Co), никель (Ni), зэс (Cu), стронций (Sr), ванадий (V).

Судалгааны үр дүнгээс харахад төслийн талбай орчмын хөрсөн бүрхэвчид хүнд металлын агууламж бүх цэгүүдэд стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу хэвийн хэмжээнд байна.

2.3. Ургамлан нөмрөг

Ургамлан нөмрөгийн судалгааны явцад ашиглалтын талбайн 0.2 га талбай, түүний орчимд ургамлан нөмрөгийн хэв шинж, бүрхцийн үндсэн үзүүлэлтүүд, биомасс, зүйлийн бүрдэл, ангилал, нэн ховор болон ховор ургамлын төрөл, зүйлүүд түүний тархалт, хамгааллын статус, ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдал өөрчлөлт, доройтлыг тодорхойлсон.

Төсөл хэрэгжих талбай нь ерхөг-улалж-алаг өвст бүлгэмдэлтэй, бүлгэмдлийн ургамлын тусгаг бүрхэц дунджаар 64%, 23 зүйлийн ургамал бүртгэгдсэн, ургац 1.3 ц/га байна. Судалгааны талбай түүний орчимд тархсан зонхилгогч ургамлын хувьд үетнээс Криловын хялгана, Саман ерхөг, Ширэг улалж, Хазаар өвс алаг өвснөөс Навтуул гичгэнэ, Имт гичгэнэ, Агь, Өлчир шарилж, Бунгийн яргуй, Буурал гандбадраа зэрэг зүйлүүд зонхилно. Одоогоор тус талбайд газар ашиглалт байхгүй, судалгааны талбайн ургамлан нөмрөг антропоген болон техноген нөлөөлөлд өртөөгүй хэвийн соргог төлөвтэй байна.

Бүлгэмдлийн зүйлийн бүрэлдэхүүний хувьд 11 овгийн, 19 төрөлд хамаарах 23 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд өвслөг ургамлууд 81 хувьтай зонхилж, сөөглөг ургамал 19 хувьтай дэд зонхилгогчоор тархсан байна.

БОАЖЯ-ны сайдын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/677 дугаар тушаалаар батлагдсан "Ашигт ургамлын жагсаалт"-д орсон элбэг тархалттай 13 зүйл ашигт ургамал бүртгэгдсэн.

Одоогоор төслийн үйл ажиллагаа эхлээгүй, ил задгай нүх, шурф, суваг шуудуу байхгүй, ургамлан нөмрөг антропоген болон техноген нөлөөлөлд өртөөгүй учир ургамалжилтыг стандартын ангиллын дагуу "Дунд доройтсон" ангилалд байна.

2.4. Амьтны аймаг

Төслийн талбай орчмын нутаг нь Монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар Хэнтийн тойрогт багтана. Хэнтийн тайгын голлох элемент болох олон зүйлийн хөхтөн амьтдын тархалттай. Богдхан уулын дархлагдсан нутгийн хүрээнд 15 овог, 27 төрөлд хамаарах 50 гаруй хөхтөн, суурин болон нүүдлийн 250 гаруй зүйлийн жигүүртэн шувуу, 3 зүйл могой, 1 зүйл бах, 1 зүйл гүрвэл болон 9 зүйл загас тэмдэглэгдсэн байдаг боловч сүүлийн жилүүдийн аялал жуулчлалын цогцолбор, цогцолборуудын суурьшил, Богдхан уулын ДЦГ-ын аялал зугаалга зэргээс ан амьтан үргэн дайжсан байдалтай байна. Зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу, бичил биетэн зэрэг амьтад байгаа болно. Энэ нь Улаанбаатар хотын ойр орчмын хүн амын нягтшил, аж ахуйн хөгжил, замын хөдөлгөөнтэй холбоотой.

Улаанбаатар хот байгуулагдаж, хөгжин тэлэхийн хэрээр тус бүс нутгийн унаган хөрс, ургамлын экосистем бүрэн алдагдсанаас амьтан, ургамлын аймгийн экосистемийн шинж төрхөд ихээр нөлөөлж, энэ хавийн амьтны зүйлийн бүрдэл нь хот суурин, хүний ойр орчимд амьдрах синантроп зүйлүүд голлон суурьших болсон.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн төв хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад амьдарч байна. Улаанбаатар хотод явуулсан богино хугацааны судалгаа (гадаргын усны далан, гол горхи, авто зам, овоолгоотой шороо зэрэг экологийн элдэв нөхцөл бүхий хэсгийг хамарсан 1-2 км замналаар) болон иргэдийн аман мэдээ, урд хийсэн судалгааны баримтад тулгуурлан амьтны аймгаас хамгийн өргөн тархсан 34 зүйлийн шавж, 17 зүйлийн шувуу, 4 зүйлийн хөхтнийг тодорхойлжээ.

Энэ орчимд шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P.montanus*) бор шувуу, хөхвөр тагтаа (*C. livia*), сохор элээ (*Milvus migrans*), шаазгай (*Pica pica*),

улаан хошуут (*Pyrrhcorax pyrrhocorax*), хар хэрээ (*Corvus corone*), хон хэрээ (*Corvus corax*) зэрэг шувууд арай олон үзэгддэг.

Хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, гэрийн хулгана нутагшиж байна. Шавжийн ангиас голдуу төрөл бүрийн цохын овог тааралдана.

2.5. Гадаргын болон газрын доорх ус

Төсөл хэрэгжих талбай нь гадаргын усны сүлжээний хувьд Хойд мөсөн далайн ай савд хамаарах бөгөөд Туул голын сав газарт багтана. Төслийн талбайд хамгийн ойр орших гадаргын томоохон урсац нь төслийн талбайгаас хойш 1.0 орчим километр зайд урсах Туул гол юм.

“Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг тогтоох тухай” Байгаль Орчин Аялал Жуулчлалын Сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 01 сарын 03-ны өдрийн А/02/01 дугаар бүхий хамтарсан тушаал гарсан. Тус тушаалын 1, 2, 3 дугаар хавсралтаар Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн хилийн зааг, хязгаарлалтын бүсийн хилийн зааг болон ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн хилийн заагийг тус тус тогтоосон.

“Монголын Кемпингийн Холбоо” НҮТББ-ийн Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд байгуулах “Отоглох орон байр байгуулах төсөл” нь Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын болон хязгаарлалтын бүс, тэжээгдлийн мужийн хилтэй давхцалгүй байна.

2.6. Тусгай хамгаалалттай газар нутаг

“Монголын Кемпингийн Холбоо” НҮТББ-ийн “Отоглох орон байр байгуулах төсөл” нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд хэрэгжинэ.

Богдхан уулын Дархан цаазат газар. Богдхан уулыг 1778 онд анх дархлан хамгаалж 1994 онд албан ёсоор Дархан цаазат газар болон баталгаажуулж, 1997 онд дэлхийн шим мандлын нөөц газрын (UNESCO) сүлжээнд бүртгэж, 1996 оноос эхлэн дэлхийн байгалийн өвд оруулахаар урьдчилсан судалгаа хийгдэж ирсэн байна. Богдхан уулыг дархалж, тахиж ирсэн түүх Хүннү гүрний мандан бадарснаас цааших 3000 жилийн тэртээгээс улбаатай. Улсын төв архивын албан баримтад 12-13-р зууны үед Хэрэйд аймгийн Ван хаан Тоорил Богд хан уулыг тахиж, Туулын хар шугуйгаар нутаглаж байхдаа “Унасан газар угаасан усаа” гэх Монгол хүний сэтгэлээр өөрийн эрх хэмжээнд онголон дархалсан түүхтэй. Өлзийт хааны тэргүүн он буюу 1294 онд гаргасан Монголын их Юань улсын хууль цаазын бичгийн 398-р бүлэгт “Богдхан уул, Отгонтэнгэр, Хан Хэнтий, Алтайн нүсэр даваа” байгалийн үзэсгэлэнт газруудыг дархан цаазтай болгож байжээ. 1778 онд тэр үеийн Монголын тэргүүний сэхээтний нэг хүрээ сайд Юндэндоржийн санаачилгаар Богдхан уулыг албан ёсоор дархалж хамгаалалтад авсан байна. 1778 онд Хүрээ Сайд Юндэндоржийн санаачилгаар Богд хан уулыг дархан цаазат болгон Манж хааны зарлиг гарч Богдхан уулын тахилга хийх тухай зарлигаас Сайд Юндэндорж Богд хан уулыг дархлуулахаар өргөсөн бичигтээ “Дөрвөн аймгийн чуулган нийлэх газар бөгөөд хормойд нь шар, хар олон түмэн хуран суух нь хүрээ оршихын дээр ан, амьтад, ой модоор элбэг баян, олон түмэндээ магтагдсан, холын жуулчдын анхаарлыг татсан энэ үзэсгэлэнт сайхан уулыг эцэг өвгөдөөс дархалж ирсэн учир үүнийг хуучин ёсоор тахин онгон дархан цаазтай болгож өгөхийг хичээнгүйлэн гуйсугай” хэмээн хүссэний дагуу Тэнгэрийг тэтгэсний 43-р оны 9-р сарын 24-ний өдөр хааны зарлигаар дахин дархалсан байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Уг төсөл хэрэгжих талбай нь байгалийн хүчин зүйлс болох ус, салхины нөлөө, мөн хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр газрын гадарга болон хэвлийн бага зэрэг эвдрэлтэй, ихэнх хэсэг харьцангуй унаган төрхөө хадгалсан, хэсэг газар ургамал хөрс талхлагдаж, ухмал нүх үүссэн, одоогийн байдлаар бага зэрэг хог хаягдалтай байна.

Төслийн барилгын ажлын үед үндсэн барилга байгууламж барих, авто зам, тоглоомын талбай, явган зам байгуулахад 1951.72 м² талбай өртөхөөр байна.

Хүснэгт 11. Төслийн нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ

№	Барилгажих талбайн нэр	Эзлэх талбай /м ² /
1.	Барилга байгууламж	785.4
2.	Авто зам	850.1
3.	Тоглоомын талбай	182.0
4.	Явган зам	134.22
Нийт		1951.72

Төслөөс газрын гадаргад үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь богино хугацааны дунд нөлөөлөл байх юм. Энэ нь төсөл хэрэгжиж эхлэх үеэс барилгын ажил дуусах хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

Төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нөлөөлөлд өртөх газрын гадаргын талбайн хэмжээг сөрөг нөлөөллийн төрлөөр ангилан үзүүлэв.

Хүснэгт 12. Газрын гадарга хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл

№	Үзүүлэлт	Эвдэгдэх талбайн хэмжээ, м ²	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн эрчим
1.	Барилга байгууламж	785.4	Бүрэн устана	Хүчтэй
2.	Авто зам	850.1	Бүрэн устана	Хүчтэй
3.	Тоглоомын талбай	182.0	Дарагдана	Нөхөн сэргээх боломжтой.
4.	Явган зам	134.22	Бүрэн устана	Хүчтэй
НИЙТ		1951.72		

Хүснэгт 13. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

№	Нөлөөлөл	Нөлөөллийн оноо								түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Газрын гадарга элэгдэл эвдрэлд орох	-1	2	3	2	1	3	2	-13	Дунд зэрэг	Төслийн 1951.72 м ² талбайд барилга, явган хүний зам, тоглоомын талбай зэрэг ажлууд хийгдэнэ.
2	Хог хаягдлаар газрын гадарга бохирдох	-1	3	2	3	1	2	3	-14	Дунд зэрэг	Хог хаягдлыг дүүргийн ТҮК-тэй хийх гэрээний дагуу зайлуулах учир бага гэж үзлээ.
	Дундаж								-13.5	Дунд зэрэг сөрөг нөлөөтэй	

3.2. Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих орчмын агаарын бохирдлын эх үүсвэр нь барилга байгууламж барих явцад үүсэх тоосжилт, барилгажилтад ажиллах машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ зэрэг болно.

Мөн агаарын бохирдлын гол үүсвэрийн нэг нь байгалийн хүчин зүйл болох шороон шуурга гэж болно. Чухам ийм үед л тоос, шороо ихээр дэгдэж агаар орчныг бохирдуулна.

Цаашид төсөл ашиглалтад орж үйлчилгээний явцад амрагч жуулчдын ирж очих машин механизмуудын түлшний шаталтаас үүсэх хорт хий, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын чанарт хими болон физикийн тодорхой нөлөөллийг бага хэмжээгээр үзүүлэх болно.

Дээрх нөлөөллийн хэлбэрийг доор дурдсан байдлаар ялган төсөөлж болох юм. Үүнд:

- ✓ Ургамалын бүрхүүл, бэлчээр тоос шороонд дарагдах
- ✓ Агаар дахь тоосны агууламж ихсэн хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлөх

Тээвэрлэлтийн /Барилгажилтын/ үед эвдэрсэн газрыг тухай бүр нөхөн сэргээх, аль болохоор олон салаа зам гаргахгүй байх, амрагч жуулчид ирж очих гол замыг цаашдаа хатуу хучилттай болгох зэрэг бололцоотой бүхий л арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

Хүснэгт 14. Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Төслийн хүрээнд үйлчлүүлж байгаа тээврийн хэрэгслээс агаарын чанарт нөлөөлөх нөлөөлөл	-1	2	2	2	1	1	1	-9	Дунд зэргийн сөрөг нөлөөлөл	Тухайн төсөл нь барилгын ажлын үед автомашинаар бараа материал тээвэрлэх тул авто машины хөдөлгөөнөөс агаарт дунд зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Харин ашиглалын үед авто зам, явган замыг хатуу хучилттай болгох тул сөрөг нөлөөлөл бага байна.
2	Ахуйн хог хаягдлыг дулааны улиралд удаан хадгалбал агаарт муудсан үнэр гарах	-1	2	2	2	1	2	1	-10	Дунд зэргийн сөрөг нөлөөлөл	Дулааны улиралд ахуйн хог хаягдлыг тухай бүр зайлуулаагүйгээс агаарт бохирдол үүсэх
3	Төслийн түүхий эдийг тээвэрлэх явцад замаас тоосжилт үүсэх	-1	1	1	2	1	1	3	-9	Дунд зэргийн сөрөг нөлөөлөл	Түүхий эдийг богино хугацаанд шороон замаар тээвэрлэнэ.
	Дундаж								-9	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй	

3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй нөлөөллүүдийг жагсаан үзүүлбэл:

Төслийн барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- ✓ Байгууламжийн материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, төсөл хэрэгжих явцад хөрс, ургамал, мод бут механик гэмтэлд өртөх
- ✓ Барилгын суурь ухах, цутгах зэрэг үйл ажиллагаанд газрын хөрс бохирдох
- ✓ Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах гэх мэт орно.

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- ✓ Төслийн барилга байгууламжийн үйл ажиллагаа явагдах үед нийт 1951.72 м² талбайн хөрс ургамал эвдрэлд орно.
- ✓ Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- ✓ Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босож орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- ✓ Амрагч жуулчдын тоо олширч түүнийгээ даган тээврийн хэрэгсэл ихэссэнээр зам жим олширч элэгдэл ихсэх, эрэг мөргөцөг нурах, эвдрэх гэх мэт болно.

Хүснэгт 15. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдал, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн оноо								Түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Авто машины зогсоолыг цементлээгүйгээс шатах тослох материал асгарч хөрсөнд нэвчих	-1	1	2	2	1	2	2	-10	Дунд зэрэг	Төслийн талбайд хатуу хучилттай авто зогсоол хийхээр төлөвлөгдсөн.
2	Төслийн талбай орчмын хөрсөн бүрхэвч устаж үгүй болох	-1	3	3	3	1	3	3	-16	Их	Төсөл хэрэгжиж буй 0.207 га талбайн хөрсөн бүрхэвч нь байшин барилга баригдсанаар унаган хөрс нь алдагдана.
3	Төв замаас төслийн талбай руу орох үед хөрсөн бүрхэвч элэгдэлд орох	-1	2	3	3	1	3	3	-15	Дунд зэрэг	Төв замаас салаад төслийн талбай руу ороход 100 м шороон замаар явдаг.
4	Хог хаягдлаар хөрс бохирдох	-1	2	3	2	1	3	2	-13	Дунд зэрэг	Хан-Уул дүүргийн ТҮК-тэй гэрээний дагуу энгийн хог хаягдлаа ачуулна.
Дундаж									-13.5	Дунд сөрөг нөлөөлтэй	

3.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Барилга байгууламж барих болон төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр /Амрагч жуулчдын хөл хөдөлгөөн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг/ зүйлийн бүрдлийн хэвийн байдалд өөрчлөлт гарч, орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдаж, тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- ✓ Төсөл орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдах,
- ✓ Тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устгах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно. /Хогийн ургамал/
- ✓ Төсөл орчмын мод бут механик гэмтэлд өртөх

Хүснэгт 16. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн оноо								Түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Ургамлан нөмрөг талхлагдан ургамлын бүрхэц буурах	-1	3	3	3	1	3	3	-16	Их зэргийн сөрөг нөлөөлөл	Төслийн талбайн ургамлан нөмрөг амрагчдын хөл хөдөлгөөнөөр ургалт нь багасаж талхагдалд орох.
2	Ургамлан нөмрөг устгах	-1	1	2	2	1	1	2	-9	Дунд зэргийн сөрөг нөлөөлөл	Тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устгах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно. /Хогийн ургамал/
3	Ургамлан нөмрөг талхагдалд орох	-1	2	3	3	1	3	3	-16	Их сөрөг нөлөөлөлтэй	Явган хүний зам тавихаар төлөвлөсөн байна.
	Дундаж								-13.6	Дунд сөрөг нөлөөлөлтэй	

3.5. Төслийн үйл ажиллагаанаас амьтны амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас амьтны амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд

- ✓ Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр бичил биетэн устгах, хордох
- ✓ Төслийн барилгын ажлын үе болон хэрэгжүүлэх хугацаанд амрагчдын тоо, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дуу чимээ зэргээс тухайн орчны амьтад үргэн дайжиж амьтны аймагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Хүснэгт 17. Амьтны аймагт нөлөөлөх байдал, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн оноо								Түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Хог хаягдлыг ил задгай хаях, өдөр бүр зайлуулаагүйгээс бичил болон мэргэгч амьтад хордох	-1	1	2	2	1	2	2	-10	Дунд сөрөг нөлөөлөл	Төслийн талбайн хог хаягдлын цэг битүүмжлэлтэй байна. Хог хаягдлыг тухай бүр зайлуулна.
	Дундаж								-10	Дунд сөрөг нөлөөлөлтэй	

3.6. Усан орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжих хугацаанд гүний ус ашиглалтыг хянах, хэрэглээг багасгах, гүний усны цооног болон гүний худгийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай.

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газар доорх усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- ✓ Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсний ус болон борооны усаар хөрсөн бүрхэвч бохирдох
- ✓ Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын голын ус ба түүний эргийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босож орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.

Хүснэгт 18. Усан орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн оноо								Түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалаагүйгээс болж салхи шуургаар дамжин орчин тойрныг бохирдуулах	-1	1	1	1	1	2	2	-8	Бага зэрэг	Хогийн зориулалтын савтай байна.
2	Төслийн ажилчид болон амрагчдын ахуйн хэрэглээ, ногоон байгууламжийн усыг хэрэглэнэ.	-1	2	2	3	1	3	3	-14	Дунд зэрэг	Төсөл нь усны хэрэгцээг өөрийн худгаас хангана.
	Дундаж								-10.0	Дунд сөрөг нөлөөтэй	

3.7. Тусгай хамгаалалттай газар нутаг үзүүлэх нөлөөлөл

Тус төсөл нь Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд хэрэгжинэ. Тус төслийг ДЦГ-ын хязгаарлалтын бүсийн дэглэм, аюулгүй ажиллагаа, холбогдох хуулийн дагуу, байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлсэн тохиолдолд сөрөг нөлөөлөл нь харьцангуй бага байх боломжтой.

Хүснэгт 19. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөлөл байхгүй	Нөлөөллийн эрчим		
			Бага	Дунд	Их
1	Тусгай хамгаалалттай бүс нутгийн ховор, ховордсон биологийн төрөл зүйлийн амьдрах орчинд нөлөөлөх	0			
2	Түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдворт газрыг эвдэхэд хүргэх	0			
3	Ой модыг огтлох, гэмтээх	0			
4	Булаг шандын усны горимд өөрчлөлт орох ба хатаж ширгэх аюултай эсэх	0			
5	Голын голдирол эвдэж өөрчлөх эсэх	0			
6	Төслийн үйл ажиллагаанд сонгосон техник, тоног төхөөрөмжийн шийдэл, түүхий эд нь байгаль орчинд хэр нийцтэй эсэх	+	+		
7	Барилга байгууламж барих хөрсний эвдрэл	-			-

8	Барилга байгууламж баригдаж дууссаны дараах хөрсний эвдрэл	-		-	
9	Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс, ургамал талхлагдах эсэх	-	-		
10	Үйчүүлэгчдийн тоо ихэссэнээр автомашин олширч агаарын бохирдол үүсгэх эсэх	-		-	
11	Хог хаягдлыг ил задгай хаяснаас орчны бохирдол үүсгэх	-	-		
12	Төслийн байгууламж хооронд хөрсний бохирдол үүсэх эсэх	-	-		

Тайлбар: (0) нөлөөлөлгүй

(-) сөрөг нөлөөлөлтэй

(+) эерэг нөлөөлөлтэй

-	6	50 %
+	1	8.3 %
0	5	41.7%

Дээрх нөлөөллийн үнэлгээнээс тооцож үзвэл

энэ төсөл тусгай хамгаалалттай бүсэд нөлөөлөх байдлаараа “бага” нөлөөлөлтэй ангилалд багтаж байна.

Төслийг хэрэгжүүлэх явцад хөрсөн бүрхэвчид хамгийн ихээр нөлөөлнө. Мөн барилга байгууламж барих үед гадаргын төрх өөрчлөгдөж, ургамлан нөмрөг талхлагдах, үйлчлүүлэгчдийн тоо ихэссэнээр автомашины тоо олширч агаарт хийн хаягдал үүсгэх, хог хаягдлыг ил задгай хаяснаар орчны бохирдол үүсгэх сөрөг нөлөөтэй.

Нөлөөллийг бууруулахын тулд төслийн барилга байгууламж хооронд явган хүний зам гаргах, машины зогсоолыг хатуу хучилттай хийх, хогийн сав болон хог хаягдлыг түр хадгалах цэгтэй байх, тухай бүрд нь ачуулах шаардлагатай.

3.8. Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Төслийн барилгын ажлын тоос болон дуу чимээний нөлөө нь ойролцоо оршин суугч иргэдэд нөлөөлөл үзүүлэх болно. Оршин суугч иргэдийн ашигладаг худгийн ойролцоо гүний усыг ашигласнаар бага гүний усны түвшин буурч энэ нь ойролцоох өрхүүдэд шууд нөлөөлж болзошгүй. Төслийн байгууламжийн ойр зорчих тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр зам тээврийн осол үүсгэхэд нөлөөлж болзошгүй.

Хүснэгт 20. Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

№	Нөлөөлөл	Нөлөөллийн оноо								түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Дүүрэгт татвар нэмэгдэх	1	3	3	3	2	3	2	16	Их эерэг	Сар бүр татвар төлөгдөнө.
2	Ажлын байр нэмэгдэнэ	1	3	2	3	2	3	2	15	Дунд эерэг	20 хүнийг жилийн 4 улирал ажлын байраар хангана.
	Дундаж оноо								15.5	Их эерэг нөлөөтэй	

3.9. Хүний эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны нөлөөллийн үнэлгээ

Төсөлд нийт 20 хүн ажиллана. Төслийн үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэнд аюулгүй байдалд учруулах нөлөөллийг энэ хэсэгт тодорхойлов. Тус төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн матрицын аргаар тодорхойлсон ба эрүүл мэнд болон аюулгүй ажиллагааны нөлөөллийн үнэлгээний матрицын тайлбарыг доорх хүснэгтэд тус үзүүлэв.

Хүснэгт 21. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Боломжит/Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн оноо								Түвшин	Тайлбар
		C	Di	S	O	E	Du	R	Σ		
1	Бэртэл, гэмтэл гарах.	-1	1	2	2	1	1	2	-9	Бага сөрөг	Хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг баримтлан ажиллах
2	Ахуйн хэрэглээний ус, хүнсний бүтээгдэхүүнээс гэдэсний өвчин гарах	-1	1	2	2	1	2	1	-9	Бага сөрөг	Ахуйн хэрэглээний усыг шинжлүүлэх, хүнсний бүтээгдэхүүний хугацаанд хяналт тавих
	Дундаж оноо								-9	Бага сөрөг нөлөөлөлтэй	

Төслийн үйл ажиллагааны явцад ажилчдыг хөдөлмөр хамгааллын сургалтад хамруулах, ажилчдыг жилд 1 удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт оруулж байх зүйтэй.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Богдхан уулын ДЦГ-т хэрэгжих төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын явцад хийсэн судалгаа, шинжилгээний ажил, холбогдох мэргэжлийн экспертүүдийн гаргасан үнэлгээ, дүгнэлтүүдийг үндэслэн төслийг хэрэгжүүлэхдээ орчиндоо үзүүлэх болзошгүй болон гол сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах болон арилгахад дараах зөвлөмж, арга хэмжээ, стандартын шаардлагыг мөрдлөг болгон ажиллах, цаг тухайд нь авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

4.1. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг үзүүлэв.

Барилгажилтын үе шат:

Бууруулах арга хэмжээ:

- ✓ Барилгын материалын хаягдлын менежментийг хангалтгүй хийснээс газрын гадарга, хөрсөн бүрхэвчийг бохирдуулах нөхцөлтэй тул газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн эвдрэлийг хамгийн бага байлгах, барилга байгууламжуудын инженерийн тооцоог нарийвчлан гаргаж газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг хамгийн бага эвдэгдэхээр зохион байгуулна.
- ✓ Шимт хөрс хуулалтыг MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт стандартыг баримтлан хуулж, хадгална.
- ✓ Барилгын ажлын үе шатанд газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах юм уу бууруулах арга байхгүй ч ашиглалтын үйл ажиллагаа болон барилгын ажил дууссаны дараа нөхөн сэргээлт хийх, ургамалжуулах, тохижуулах ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэснээр сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой. Ялангуяа хөрс, орчны ургамлыг нөхөн сэргээх, ургамалжуулах, эдэлбэр газарт нөхөн сэргээлт хийж хөрс, ургамлын хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.
- ✓ Барилгын ажилчдын болон барилгын ажлын үе шатанд гарах хатуу хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хог хаягдлын менежментийн бүлэгт тусгасны дагуу менежментийг хийнэ. Барилгын хог хаягдлыг Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаалын хавсралт “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын дагуу менежментийг гүйцэтгэнэ.

4.2. Агаарын чанар

Барилгажилтын үе шат:

Бууруулах арга хэмжээ:

- ✓ Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээний хяналт болон түүнийг тогтмол сайжруулах үйл явцыг төлөвлөх зорилгоор үйл ажиллагааны бүхий л үе шатанд агаарын чанарын хяналт шинжилгээг тогтмол хийнэ.
- ✓ Барилгын ажлын үед шороон замаас том оврын техник хэрэгслүүдийн хөдөлгөөнөөр тоосжилт үүснэ. Уг тоосжилтыг бууруулах зорилгоор шороон замыг дагтаршуулах, түр хайргаар хучих зэрэг арга хэмжээг тогтмол авна.
- ✓ Хуурайшилттай, салхи шуурга ихтэй хавар, намрын улирлуудад үүсэх тоосжилтыг багасгахын тулд тогтмол услагаа хийнэ.
- ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг хязгаарлаж, тогтмол хянана.

4.3. Гадаргын болон газрын доорх ус

Барилгажилтын үе шат:

Барилгын ажлын үе шатанд төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг дараах хэсэгт нэгтгэн үзүүлэв. Үүнд:

- ✓ Барилгын ажлын үед техникийн хэрэгцээнд ус ашиглахдаа үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны нөөц болон усны боломжит нөөцөөс хэтрүүлэн ашиглахгүй.
- ✓ Усны урсцыг гадагшлуулах хоолой, сувгийн тооцоог нарийвчлан хийх, даланг тодорхой тооцоо, зураг төслийн дагуу хийх, хөрс эвдрэхээс сэргийлэн ажиллана.

4.4. Ургамлан нөмрөг

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Барилгажилтын үед:

- ✓ Хуурайшилт ихтэй үед хөрс, шороо хийсэхийг багасгах, услах, үржил шимт өнгөн хөрсийг хамгаалах, нөхөн сэргээж тэгшилсэн газрыг аль болох богино хугацаанд өнгөн хөрсөөр хучиж ургамалжуулах, зүлэгжүүлэх, нөхөн сэргээх арга хэмжээ авна.
- ✓ Машин техникээс хаягдаж, асгарч болзошгүй асгаралтыг тогтмол хянах (~~хөрөнний гидрокарбонаты бөхирдөл төдөрхөйлөгч багажний хөрөнний хяналт шинжилгээний хөтөлбөрт ашиглаж хөрсөнд агуулагдах нефтийн бүтээгдэхүүний шинжилгээг хийлгэнэ~~)

4.5. Тусгай хамгаалалттай газар нутаг

Төсөл хэрэгжих үйл ажиллагааны бүхий л түвшинд Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн дэглэмийг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

- ✓ Хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх;
- ✓ Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх;
- ✓ Ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах;
- ✓ Рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ашиглах;
- ✓ Байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах;
- ✓ Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах;
- ✓ Зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол бүтээл туурвихад ашиглах;
- ✓ Уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх;
- ✓ Нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах,

Дархан цаазат газарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- ✓ Газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх;
- ✓ Байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх;
- ✓ Ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх;

- ✓ Хортон шавьж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник, бодис хэрэглэх;
- ✓ Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглахаас өөр барилга байгууламж барих;
- ✓ Хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах;
- ✓ Тухайн газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж, буу авч явах;
- ✓ Аргагүйгээс бусад тохиолдолд тухайн газрын хамгаалалтын захиргаанаас урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх;
- ✓ Өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх;
- ✓ Нуур, мөрөн, гол горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах;
- ✓ Хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах.

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн, нэгж, байгууллага дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- ✓ Ашиглаж байгаа газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад дамжуулан ашиглуулах;
- ✓ Тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хууль болон хамгаалалтын горимоор хориглосон, гэрээнд зааснаас өөр буюу байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулах.
- ✓ Ашиглагчаас газрыг хуульд заасан үндэслэлээр эргүүлж авах тохиолдолд тусгай хамгаалалттай газар нутгаас түүнд дахин газар олгохгүй байж болно.

4.6. Удирдлага зохион байгуулалт

- ✓ Байгаль орчныг хамгаалах хууль, орчны байгалийг сүйтгэхгүй байх талаар мэдээлэл сурталчилгаа, анхааруулах хуудас бэлтгэж, сурталчлах
- ✓ Аялал жуулчлалын цогцолборын дотоод дүрэм, журмыг боловсруулж ажилчид, үйлчлүүлэгчдэд танилцуулж мөрдүүлэх
- ✓ Аливаа гал түймрээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжүүдийг танилцуулж байнга анхааруулж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, болзошгүй гэнэтийн гал түймэр унтраах хэрэгслийг дүрэм журмын дагуу бэлтгэж бэлэн байлгах, гал гарсан тохиолдолд богино хугацаанд унтраах арга барицыг эзэмшүүлж ажилтнууд тодорхой чиглэлээр ажиллана.
- ✓ Байгаль хамгаалах талаар авсан арга хэмжээ, байгаль орчны төлөвлөгөөг хэрхэн биелүүлсэн, хяналт шинжилгээний дүнгийн талаар жил бүр тайлан бичиж орон нутгийн захиргаа, байгаль орчны хяналтын албадад тогтоосон хугацаанд хүргүүлж байна.
- ✓ Тухайн орон нутгийн байгаль, түүх, соёл, зан заншилтай танилцах хөтөлбөртэй байгальд түшиглэсэн хариуцлагатай, эко - аяллыг орон нутагт эдийн засгийн ашигтай, тогтвортойгоор зохион байгуулна.
- ✓ Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.
- ✓ Цогцолборын ажилтан тус бүрийг болзошгүй ослын үед ажиллах сургалтад хамруулж дадлагажуулах.

- ✓ Зураг төслийг цахилгаан техникийн ашиглалт болон аюулгүй техникийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх, холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулсан байх
- ✓ Төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн дэд бүтэц (*цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга, холбоо дохиолол*)-д бүрэн холбогдоход эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулна.
- ✓ Эдэлбэр газар үер, газар хөдлөлт, аянга, галын аюулгүй байдлыг хангасан хамгаалалттай, болзошгүй ослын үед ашиглах заавар, схем зургийг нүдэнд харагдахуйц газар ил байрлуулах
- ✓ Анхны тусламж болон яаралтай тусламж үзүүлэх нөхцөлөөр хангана.

4.9. Хатуу хог хаягдлын түр цэг байгуулах болон зориулалтын хогийн савыг ашиглах

Хатуу хог хаягдлыг түр хураан хадгалах зориулалтын сав байрлуулаагүй нөхцөлд орчноор хог хаягдал тархах, салхиар зөөгдөх нөхцөл бүрдэх бөгөөд энэ нь олон талтай сөрөг нөлөөллийн эх үүсвэр болж болзошгүй юм. Иймээс шаардлага хангахуйц хэмжээнд хатуу хаягдлын төрлүүдэд зориулсан түр хураан хадгалах төвлөрсөн цэг байгуулна.

Хатуу хог хаягдлын түр цэгийн байршлыг сонгохдоо салхины ноёлох чиглэл, газрын хэвгийг, эрүүл ахуйн бүсийн зөвшөөрөгдөх зай хэмжээ зэргийг харгалзан байрлуулна.

Ангилал бүхий хогийн савны амыг салхинд хогийг тараахгүй байхаар бат бөх зориулалтын битүү тагтай байрлуулна.

Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбар, тэмдэгжүүлэх, хог хаягдлын төрөлд зориулсан хаягжуулалт хийн байршуулах, хуурай хог хаягдалд болгоомжгүй үйлдлээс болон аль нэг шалтгаанаар гал гарах үед ашиглах гал унтраагуур, элс хүрз зэргийг бэлэн байлгана.

Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдлыг ангилах ба ангиллын дагуу хог хаягдлыг төрлийн кодоор ангилан ялгаж, тээвэрлэлт хийнэ.

Хог хаягдлыг ангилахдаа аль болох овор хэмжээг нь бууруулах хэрэгтэй. Тухайлбал лаазыг гишгэн жижиг болгох, хуванцар савны тагийг авч хавтгайлах, цаасан хайрцгийг нугалах гэх мэтээр овор хэмжээг багасгаж хуримтлуулна.

Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Дахин ашиглах болон шатааж болох боломжтой хог хаягдал: төрөл бүрийн цаас, картон цаас, шингэний тетропак савлагаа, хуванцар сав, сав баглаа боодол, хөнгөн цагаан, металл, зэс, гууль, саа, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут
- ✓ Нийтийн эзэмшлийн талбай, үйлчилгээний орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байрлуулна.
- ✓ Эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайг хог хаягдалгүй, цэвэр цэмцгэр байлгана.
- ✓ Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт зайлуулна.

Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Европын холбооны улсын хог хаягдлын олон улсын ангилал зэргийг үндэслэн тус бүтээн байгуулалтын барилгын ажил болон цаашдын үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдлыг ангилсан байх шаардлагатай бөгөөд эдгээр ангиллын дагуу хог хаягдлыг төрлийн кодоор ангилан ялгаж, тээвэрлэлт хийх хэрэгтэй.

Барилгын ажлын үед үүсэх хог хаягдлыг Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48-р тушаалаар батлагдсан “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх,

дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам"-ын дагуу зохицуулна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө:

Хүснэгт 22. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /2026 он/

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
АГААР ОРЧИН					
Богдхан уулын ДЦГ орчмын авто тээврийн хөдөлгөөн ихэссэнээс агаар дахь тоосны хэмжээ CO, SO ₂ , NO ₂ ихсэж, орчны хүчилтөрөгчийн /O ₂ / хэмжээ багасах, үйлчлүүлэгч иргэд, аялагчдын автомашины хөлөөр үүсэх тоосжилт, утаа тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчныг бохирдуулах, ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэж болно.	Тоосжилт бууруулах зорилгоор төв зам хүртэлх замыг хатуу хучилттай болгох хайрга чулуу дэвсэх	Төслийн хүрээнд эхний жил	10,000.0	Үйл ажиллагааны турш	Агаарын тухай хууль MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага /шинэчилсэн найруулга/
	Хуурайшилттай, салхи шуурга ихтэй хавар, намрын улирлуудад үүсэх тоосжилтыг багасгахын тулд тогтмол услагаа хийнэ.	Төслийн хүрээнд	1,500.0	Үйл ажиллагааны турш	
	Тээврийн хэрэгслийн хурдны хязгаарлалт, зам талбай, зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ, анхааруулгыг байршуулах	Төслийн хүрээнд	1,500.0	Үйл ажиллагааны турш	
Нийт дүн			13,000.0		
УСНЫ НӨӨЦ, ЧАНАР					
Төслийн барилгажилтын үе шатанд /цэвэр бохир усны шугам, / гадаргын болон гүний усанд нөлөөлөх, Шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, Бохир ус дамжуулах шугам хоолойг зориулалтын бус материалаар хийх, шугам хоолойд гэмтэл үүсэж гүний усыг бохирдуулж болзошгүй.	Усны урсцыг гадагшлуулах хоолой, сувгийн тооцоог нарийвчлан хийх, даланг тодорхой тооцоо, зураг төслийн дагуу хийх, хөрс эвдрэхээс сэргийлэн ажиллана.	Төслийн хүрээнд	3,500.0	Үйл ажиллагааны турш	Усны тухай хууль /шинэчилсэн найруулга/

Нийт дүн		3,500.0		
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ				
Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс байгууламжуудын дор дарагдаж, зам тээвэр, бүтээн байгуулалт болон бусад үйл ажиллагаатай холбогдож элэгдэл, эвдрэлд өртөнө. Барилгын ажлын улмаас хаягдлаар хөрс бохирдож болзошгүй	Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийнэ /төслийн хашаанаас гадна талбайд олон салаа зам гаргахаас сэргийлэх/	Төслийн талбайд	500.0	Төсөл хэрэгжих хугацаанд
	Шимт хөрс хуулалтыг MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт стандартыг баримтлан хуулж, хадгална.	Төслийн талбайд	1,000.0	
Нийт дүн			1,500.0	
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал			17,500.0	
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ				
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох орон нутгийн байгаль орчны алба, ДЦГ-ын хамгаалалтын захиргаа болон байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Төслийн хүрээнд		1,500.0	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	Ажилчид		3,500.0	Эрүүл мэндийн тухай хууль
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний зардал			5000.0	

Тэрбум мод үндэсний хөтөлбөр, орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө:

Тус төслийн онцлогоос хамааран нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн талбайн ногоон байгууламжийг байгуулах болон түүний арчилгаа, тордолгоо хийх ажлыг оруулсан. Төслийн онцлогоос хамааран ногоон байгууламжийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралт “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийг үйлдвэрийн орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэлтийг сайжруулах үүднээс мод тарих ажлыг оруулсан. Ногоон байгууламж байгуулах зөвлөмжийг төслийн БОННУ-д тодорхой тусгаж зардлын тооцоог гаргасан ба энэхүү зардлыг төслийн бүтээн байгуулалтын төсөвт суулгаж өгөх нь зүйтэй.

Хүснэгт 23. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /2026 он/

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж, мод бүхий зурвас байгуулах	Нийт ашиглалтын талбайн 10% хүртэлх талбайд ногоон байгууламж хийх	Модны төрөл /Шар хуайс, 20 ш/ /Хайлаас, 180 ш/	6,400.0	Төсөл хэрэгжих хугацаанд	- Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт. - MNS5914:2008; Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. MNS5916:2008; - Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS5918:2023;
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал			6,400.0		

Тэрбум мод үндэсний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 24. Тэрбум мод үндэсний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /2026 он/

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутагтай тохиролцон жилд 1500 ш мод тарихаар төлөвлөсөн.	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Нийслэлийн Байгаль орчны газар болон Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргаатай тохиролцох, санал авах	6000,0	Төсөл хэрэгжих хугацаанд	- Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт. - MNS5914:2008; Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. MNS5916:2008; - Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MNS5918:2023;
Тэрбум мод үндэсний хөтөлбөр, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал			6000,0		-

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө:

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө байхгүй.

Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө:

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй болно.

Гэвч "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-ийн 27.8-д хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна гэж заасан байдаг. Тиймээс палеонтологи, археологийн судалгаа, хайгуул хийж, шинжилгээний үр дүнг мэдээлж болзошгүй аюулд өртөхөөс урьдчилан сэргийлэх хэрэгтэй.

Тус хуулийн 29.1-д зааснаар соёлын өвийн судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлангийн нэг хувийг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлнэ.

- ✓ Соёлын өвийг хамгаалах, хадгалах МУ-ын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх.
- ✓ Түүхийн болоод соёлын өв сангийн зүйлүүд олох буюу олох магадлал ихтэй бол нэн даруй төслийн үйл ажиллагааг зогсоож, орон нутгийн засаг захиргаа мөн улс төрийн болон холбогдох шинжлэх ухааны судалгааны байгууллагуудад мэдэгдэх.
- ✓ Түүх, соёлын дурсгал болон ард түмний зан үйлд харшлах зүйлсийг хөндөхгүй байхын үүднээс талбайд орших дурсгалт зүйлст хамгаалалт хийх, ойр орчмоор нь машин техник явуулахгүй байхаар зохион байгуулна.

Эрх зүйн хязгаарлалт:

МУ-ын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон ЮНЕСКО-гоос баталсан олон улсын эрх зүйн актуудад соёлын төрөл зүйл, соёлын өвийг хамгаалахтай холбоотой асуудлуудыг тодорхой тусгасан байдаг. Үүнд:

- ✓ 1972 онд баталсан "Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах" тухай конвенц,
- ✓ 2001 онд баталсан "Соёлын төрөл зүйлийн тухай" тунхаглалд соёлын өв, түүний төрөл зүйл нь бүх хүн төрөлхтний өв хөрөнгө бөгөөд өнөө үе болон хойч үеийн ашиг сонирхлын үүднээс тэдгээрийг хүлээн зөвшөөрч, хадгалж хамгаалах тухай заасан байна.
- ✓ МУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 7.1-д "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна" гэж заасан.
- ✓ МУ-ын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.8-д хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна. 27.9-д урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах

зардлыг захиалагч хариуцна. 27.10-т урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно гэж заажээ.

- ✓ Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа нь эрдэм шинжилгээний болон авран хамгаалах үндсэн чиглэлтэй байх бөгөөд соёлын биет өвийн судалгаа, шинжилгээг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ.

Хүснэгт 25. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө /2026 он/

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Соёлын өвийн зааварчилгаа	Төслийн талбай	200.0	Газар шорооны ажилд оролцох хүн	Соёлын өвийн тухай хууль
Түүх соёлын дурсгалт газруудад ажиглалт мониторинг хийх	Төслийн талбай, түүний орчимд	500.0	Төсөл хэрэгжүүлэгч	Соёлын өвийн тухай хууль
Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал		700.0		

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө:

Хүснэгт 26. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө /2026 он/

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Нийт төсөл хэрэгжих талбай, барилга байгууламжид	400,0	Жилд 1 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль, "Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага"
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	200,0	Жилд 2 удаа	
	Хамгаалалтын далан, жалга сайрыг цэвэрлэж байх	Төслийн талбай орчим	200,0	Жилд 2 удаа	
	Өөрийн байгууламжид үер усны аюул, гал түймрээс урьдчилан сэргийлэх тусгай бүдүүвч схем боловсруулан ажиллах	Төслийн хүрээнд	250,0	Төслийн эхэнд	
	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг	Төслийг бүхэлд нь	200,0	Жил бүр	

хангуулах арга хэмжээ зохион байгуулах				
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал		1,250.0		

Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт 27. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ахуйн хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх /БУММ ХХК/	Төслийн хүрээнд	230.0	Төслийн эхэнд	- Хог хаягдлын тухай хууль - Ариун цэврийн тухай хууль - MNS 6426:2013 - Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,
	Барилгын ажлын үед стандартын шаардлага хангасан хогийн сав байрлуулах,	Төслийн хүрээнд	1,500.0	Төслийн эхэнд	
Нийт дүн			1,730.0		

БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Хүснэгт 28. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ,түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
--	-------------------------------	------------------	---------------	---------------------------------	------------------------

Богдхан уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргаанд	БОМТ биелэлтийн тайланг хүргүүлэх	Дүгнэх хуудас авах	11-р сарын 1	Бичгээр	"Монголын Кемпингийн Холбоо" НҮТББ болон Үнэлгээний мэргэжлийн байгууллага
БОУАӨЯ-ны ХБОБНГ-т	БОМТ биелэлтийн тайланг хүргүүлэх	БОМТБТайланг хүлээн авсан дүгнэх хуудсыг БОМТ хамт хүргүүлэх	12-р сар	бичгээр	"Монголын Кемпингийн Холбоо" НҮТББ болон Үнэлгээний мэргэжлийн байгууллага

Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь "Монголын Кемпингийн Холбоо" НҮТББ-ын Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд байгуулах "Отоглох орон байр байгуулах төсөл" нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын хуулиудын дагуу "Монголын Кемпингийн Холбоо" НҮТББ нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам /-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг "Монголын Кемпингийн Холбоо" НҮТББ хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

Хүснэгт 28. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1. Агаарын чанар					
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 1 цэг сонгох	Агаарын найрлага: жилд 1 удаа	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 40.0 х Жилд 1 удаа* 5 жил Нийт 200.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх		Тоосны төслийн талбайд 1 цэгт жилд 1удаа	Шинжилгээний зардал: 1 удаагийнх 50.0 х x 1 цэг x жилд 1удаа *5 жил Нийт 250.0	
1.3	Дуу шуугиан, чичиргээ:		Жилд 1 удаа	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 30.0 х Жилд 1 удаа* 5 жил Нийт 150.0	
2. Усны хяналт шинжилгээ					

2.1	Усны ерөнхий шинжилгээ	Унд ахуйн уснаас	Жилд 1 удаа	46.0*1 удаа* 5жилд= Нийт 230.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3. Хөрсний бохирдол					
3.1	Хөрсний хими физик шинж чанар, хүнд металлын шинжилгээг хийлгэх	Төслийн талбайд 1 цэг сонгох	Жилд 1 удаа, 1 цэгт	1х2 дээж х жилд 1 удаа х 5 жил/30.0+33.0/ Нийт 330.0 /Хөрсний химийн шинжилгээ -30.0 төг, хүнд металлын шинжилгээ- 33.0 төг/	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3.2	Ургамлын төрөл зүйлийг нарийвчлан тогтоох, ховор болон нэн ховор ургамал байгаа эсэхийг тодорхойлох	Төслийн талбайд	Жилд нэг удаа зундаа	300,0*5жил = 1500,0	
ОХШХ-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын жилийн нийт зардлын дүн				2,660.0	

4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Богдхан уулын Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс, Зайсангийн аманд байгуулах "Монголын Кемпингийн Холбоо" НҮТББ-ын "Отоглох орон байр байгуулах төсөл"-д 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардлыг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 29. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн /2026 он/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт дүн /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	мян.төг	18,000.0
2	Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	мян.төг	5,000.0
3	Орчны тохижилт, нөхөн сэргээлт, ногоон байгууламж, мод бүхий зурвас байгуулах	мян.төг	6,400.0
4	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	мян.төг	700.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	мян.төг	1,730.0
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	мян.төг	1,250.0
7	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	мян.төг	2,660.0
8	Байгаль орчны төлөвлөгөөт аудит	мян.төг	-
Нийт		мян.төг	35,740.0
1	Тэрбум мод үндэсний хөтөлбөр	мян.төг	6,000.0
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн			41,740.0

2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 41,740.0 /дөчин нэгэн сая долоон зуун дөчин мянган төгрөг/ зарцуулахаар төлөвлөв.



2011.01.13

/Бүртгэсэн өн, сар, өдөр/

МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000012523

9071017019

/Улсын бүртгэлийн дугаар/

8042306

/Регистрийн дугаар/

Монголын кемпингийн холбоо

Нийгэмд үйлчилдэг ТББ

/Хуулийн этгээдийн нэр, хариуцаагчийн хэлбэр/

Дүрэм

/Мүсэл байдгуулах баримт бичиг/

Тогтоол

/Илийдсэрийн нэр/

01

/Дугаар/

1997.09.25

өн, сар, өдөр

751400

/код/

Кемпинг аялал зохион байгуулах, хөгжүүлэх, сурталчлах, сургалт, үүлээлт явуулах, судалгаа хийх

/Идсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

/код/

/Гулалх эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй

хугацаа

5

/шилүүдийн тоо/

20,0

/дөрийн хөрөнгийн хэмжээ, мянган тогтоогоор/

Чингэлтэй, 4-р хороо, Бага тойруу, Хувьсгалчдын- 9Б Зоос гоёл ХХК-ны - 205 тоот, утас1:99090648, утас2:11-319645, факс:

/хуулийн этгээдийн албан ёсны хэл/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын
Хуулийн этгээдийн бүртгэлийн газар

Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр

Дансны төрөл

Дансны дугаар

Бүртгэгч, ажиглан,

Голголт төл банк

Төгрөгийн

1410001245

Г. Ганзориг

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлт, зөвлөлийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн Огноо Улсын Бүртгэгч П.Ганзориг	Ажиглагч, тэмдэг Улсын Бүртгэгч П.Ганзориг
1	Дүмийн сан 0-р хэсгэд 20.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2011.07.22	П.Ганзориг
2	Хувь нийлүүлэгч 2-ээр нэмэгдэж, 2-ээр хэсгэд үүсгэн байгуулагчийн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2012.04.02	П.Ганзориг
3	Батжав овогтой Цэцэгдэх -г УЗ-ын дарга-р томилогсныг бүртгэв.	2014.01.20	Э.Эрдэнэбилэг
4	Хувь нийлүүлэгчээс 3 нэмэгдэж, 3 хэсгэд үүсгэн байгуулагчийн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2014.04.29	О.Шижиртуяа
5	Ареис овогтой Янсанмаа -г УЗ-ын дарга-р томилогсныг бүртгэв.	2014.04.29	О.Шижиртуяа
6	Мөнхбавтар овогтой Тэглүүлэн-г Удирдах зөвлөлийн дарга-р сонгосон(томилогсон)-ыг бүртгэв.	2022.02.01	Ш.Очирсүрэн
7	Гишүүн 5 нэмэгдэж 5 хэсгэд Гишүүн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2022.02.01	Ш.Очирсүрэн
8	Эцсийн өмчлөгч 1 ирэн бүртгэв.	2022.02.01	Ш.Очирсүрэн
9	Мэлээншүр овогтой Чимсангай-г Удирдах зөвлөлийн дарга-р сонгосон(томилогсон)-ыг бүртгэв.	2024.05.27	Б.Нарантуяа
10	Гишүүн 1 нэмэгдэж 1 хэсгэд Гишүүн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2024.08.27	Б.Нарантуяа
11	Эцсийн өмчлөгч өөрчлөгдсөнийг бүртгэв.	2024.08.27	Б.Нарантуяа
12	Улаанбаатар, Хөн-Уул, 11-р хороо, зүйсэл, зүйсэл, 156, 2 давхар 2.7 тосот Утас1: 99020646, Утас2: 11319645. Факс: хаягийг шинээр бүртгэв.	2024.08.27	Б.Нарантуяа

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцахаг хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



“МОНГОЛЫН КЕМПИНГИЙН
ХОЛБОО” НҮТББ-Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ**

Засгийн газрын байр 12, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.mecc.gov.mn

2026.05.28 № 11/3226
танай _____-ны № _____-т

Ерөнхий үнэлгээний дүгнэлт хүргүүлэх
тухай

Танай байгууллагаас ирүүлсэн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Богдхан Уулын ДЦГ-ын Зайсангийн аманд хэрэгжих “Аялагч зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалттай орон байр барих, ашиглах” төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж шийдвэрлэсэн байна.

Иймд ерөнхий үнэлгээний дүгнэлтийн гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулж 2027 оны 1 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлнэ үү.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас, бичиг баримтын бүрдлийг хянасан маягтыг хавсаргав.

Хавсралт 6 хуудастай.

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСЭЛТ, БАРИМТ БИЧИГ
ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ**

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Монголын Кемпингийн Холбоо” НҮТББ, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, 69-р байр 45 тоот.

Холбоо барих утас: 88181888 , 99118707

Төслийн нэр: “Аялагч зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалттай орон байр барих, ашиглах” төсөл

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр,байршил: Хан-Уул дүүргийн Богдхан Уулын ДЦГ-ын Зайсангийн аманд аманд хэрэгжинэ.

Баримт бичгийн нэр	Шаардлагатай эсэх	Шаардлага хангасан эсэх	Тайлбар
Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/	Тийм	+	2026.05.15-ны өдрийн 01/37 тоот
Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөл	Тийм	+	2026 онд Нийслэлийн ерөнхий архитекторын баталсан зураг төсөл
Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан эсэх /газрын зөвшөөрөл, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал/	Тийм	+	БОАЖС-ын 2024.06.21-ны өдрийн А/489 дүгээр тушаалаар олгосон №0243484 тоот гэрчилгээтэй.
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	Үгүй	-	Шаардлагагүй.
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан	Тийм	+	Эрх бүхий “Грийн Ассесмент” ХХК боловсруулсан.
Төсөл хэрэгжих орчны тойм зураг (топо, сансрын)	Тийм	+	Илгээсэн
Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт	Тийм	+	Хан-Уул дүүргийн ЗД-ын 2025 оны №02/651 дугаартай албан бичиг
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/	Тийм	+	9071017019 8042306
Тусгай тэмдэглэл: “Монголын Кемпингийн Холбоо” НҮТББ -ийн “Аялагч зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалттай орон байр барих, ашиглах” төслийн “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-г Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүнд тавигдах шаардлагын дагуу боловсруулахыг мэдэгдэж байна.			
Ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт, материалыг хянасан: БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖЭЭЧ			Б.СОЛОНГО

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХУУДАС**

2026 оны 05-р сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2026/БС-104

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Монголын Кемпингийн Холбоо” НҮТББ, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, 69-р байр 45 тоот.

